



Хувийн дугаарын үнэмлэхтэй болж,
аятухтай амьдарцгаая!



My number карт гэж юу вэ?

Анхны удаа авхад үнэ төлбөргүй!

Тус картыг биеийн байцаалт болгон хэрэглэх боломжтой ба таны “Хувь хүний дугаар” болон цээж зурагтай карт юм. IC чипийн цахим гэрчилгээг ашиглан цахимаар визний өргөдөл болон татварын тайлан (e-Tax) гэх зэрэг олон төрлийн үйлчилгээ хийх боломжтой юм.

Урд тал



Ард тал



Хууль зүйн яамны вэбсайт дээр 16 улсын хэлээр танилцуулга бий!



шалгаарай!

Холбоо барих !

Япон хэл



My number-н талаар ерөнхий мэдээлэл-Төлбөргүй утас

TEL:0120-95-0178



※Утсанд хариу өгөх боломжтой цаг нь гаригаас хамаарч өөр өөр байна. Даваагаас Баасан гариг хүртэл 9:30-20:00 цаг хүртэл
Бямба, Ням, Баярын өдрүүдэд 9:30-17:30 цаг хүртэл
(My number карт, My number point-н талаар 9:30-20:00 цаг хүртэл)

Гадаад хэл



My number карт-н тухай

TEL:0120-0178-27



Холбогдохгүй үед 0570-064-738

※Хэлээс хамааран утсаар хариу өгөх цаг өөр байна.

- English (Англи хэл)、中文 (Хятад хэл)、한국어 (Солонгос хэл)、Español (Испани хэл)、Português (Португал хэл)
➡ 9:30-20:00 цаг хүртэл
- ภาษาไทย (Тайланд хэл)、नेपाली भाषा (Балба хэл)、Bahasa Indonesia (Индонез хэл)
➡ 9:00-18:00 цаг хүртэл
- Tiếng Việt (Вьетнам хэл)、Pilipino (Филиппин хэл)
➡ 10:00-19:00 цаг хүртэл



My point-н тухай

TEL:0570-028-125

My point-д бүртгүүлэх тухай эндээс лавлана уу!

※Холбоо барих цаг:


- English (Англи хэл)、中文 (Хятад хэл)、한국어 (Солонгос хэл)、Español (Испани хэл)、Português (Португал хэл)
➡ 9:30-20:00

Карт захиалах, My number point-г авах арга

1-р алхам Бүртгэлийн маягт бөглөнө

★Бүртгэлийн маягт болон илгээх шуудангийн хаягийг Immigration дээрээс авах боломжтой!

- Бүртгэлийн маягтыг бөглөнө.
- 6 сарын дотор авхуулсан цээж зургаа наана.



“Хувь хүний дугаар”-н мэдэгдлийн хуудсанд таны хувь хүний дугаар бичигдсэн байгаа!

Зүүн талын дотор байгаа дугаар таны “Хувь хүний дугаар” болно.

“Хувь хүний дугаар”-н мэдэгдлийн хуудас нь хаягийн бүртгэл хийлгүүлээд 2-3 долоо хонгийн дараа баталгаат шуудангаар гэрт хүргэгдэнэ. **Хаягийн бүртгэл хийлгүүлж авжаагүй бол харъя дүүрэг, хотдоо бүртгэл хийлгэх хэрэгтэй. Хаягаа бүртгүүлэхдээ картаа захиална уу.**

Картаа компьютер болон гар утас, цээж зургийн автомат машинаар (зөвхөн Япон хэл) захиалах боломжтой.

2-р алхам Картаа захиалж авна

“Хувь хүний дугаар”-аа мэдэж байгаа бол

① Бүртгэлийн маягтаа бөглөн, илгээх хаягийг наасан дугтуйнд хийн явуулна.

② Шуудангийн хайрцагт хийнэ.

Ойролцоогоор сарын дараа • • •

③ Захидал хаягаар ирнэ.

④ Захидал дээр заасан газар руу очно.

⑤ Хүлээн авах цонхонд нууц дугаараа баталгаажуулан, картаа авна.



“Хувь хүний дугаар” болон хэрхэн бөглөхөө мэдэхгүй байгаа бол

① Оршин сууж буй дүүрэг, хотын захиргаа руу явна.



② Хүлээн авах цонхонд маягтаа бөглөн, хураалгана.

Ойролцоогоор сарын дараа • • •

③ My number карт гэрт ирнэ. ※Дүүрэг, хотоосоо хамааран зүүн хүснэгт дэх ③~⑤ дагуу явах тохиолдол ч бий.



Цээж зургаа авхуулахдаа



- Хэмжээ: урт 4,5 см × өргөн 3,5 см
- Эгц урдаас, малгайгүй, цулгүй фонтой байх. Хар цагаан зураг байж болно

- Цулгүй фонтой газар авхуулаагүй
- Царай тод гараагүй
- Малгай, нарны шил зүүсэн зураг болохгүй.



Хууль зүйн яамны вэбсайт дээр 16 улсын хэлээр танилцуулга бий!



шалгаарай

3-р алхам My number point-д бүртгүүлнэ

My number point нь таны сонгосон цахим төлбөрийн үйлчилгээнд нэмэгдэж орно. Өөрийн хүссэн цахим төлбөрийн үйлчилгээг сонгоно уу. **Гар утас, компьютер, my number point-н үйлчилгээг үзүүлэх цэгээс бүртгүүлж болно!**

Дэлгэрэнгүйг • • •

TEL:0120-95-0178(Япон хэл)

TEL:0570-028-125(Гадаад хэл)

руу холбоо барина уу!



※Холбоо барих цаг: 9:30-20:00 хүртэл

※5 улсын хэлээр ярих боломжтой

English (Англи хэл), 中文 (Хятад хэл), 한국어 (Солонгос хэл), Español (Испани хэл), Português (Португал хэл)

Ийм тэмдэгтэй газарт бүртгэнэ